

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ХАМТ ОЛНЫ ДУНД НИЙГЭМШҮҮЛЭХ БОЛОВСРОЛ ОЛГОХ АСУУДЛЫН ТАЛААР

Л.Рэнцэнханд,
Хүмүүнлэгийн Их Сургууль
ira_soyol@yahoo.com

Annotation

Mongolia has paid attention to the public quality education, which being inter connected with global educational reform, developing to the nation.

According to this progress, The joint plan was worked out by Education, Science and Culture Ministry, Health Ministry and Social Welfare and Labour Ministry, named "To educate the disabled children and involving them in School" in 2003.

These children live and study separately from society and colleagues. Minority of them study at special schools, majorities can't find out and gain complete knowledge.

Therefore it is important to socialize and collectivize them. In other words they will able to study and live at ordinary schools and environment with their generation and friends.

Хураангуй:

Монгол улс дэлхий нийтийн боловсролын шинэчлэлийн чиг хандлагад нийцүүлэн, иргэддээ хүртээмжтэй, чанартай боловсрол олгох зорилго тавин ажиллаж байгаа өнөө үед “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах” хөтөлбөр 2003 онд БСШУЯ, ЭМЯ, НХХЯ-ны хамтарсан шийдвэрээр боловсруулан гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй ба боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүд нь нийгэм хамт олноос тусгаарлагдаж, тэдний цөөнх нь тусгай сургуульд хамрагдаж дийлэнх нь боловсролд хамрагдах боломжгүй байгаа тул энэхүү өгүүлэлд эдгээр хүүхдүүдийг хамт олны дунд нийгэмшүүлэх, өөрөөр хэлбэл энгийн орчинд хэвийн хөгжилтэй үе тэнгийнхэнтэйгээ хамт амьдарч сурч боловсрол эзэмших нь чухал юм гэдгийг хэлэхийг зорив.

Түлхүүр үг:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийгэмшүүлэх, тусгай хэрэгцээт боловсрол, сурах сургах арга барил, эцэг эх багшийн туслалцаа

Ориил:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох ариун үйлсийг манай оронд анх одоогоос 40 жилийн өмнө эхэлж байжээ. Монгол улсын гавьяат багш Ц.Лантуу, ахмад согог зүйч Ш.Мижид-Очир, М.Балдорж, Я.Цэвээнлхазал нарын зэрэг багш сурган хүмүүжүүлэгч тусгай боловсролын анхны байгууллагуудыг бий болгож, боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ аж төрөх арга ухаанд сургаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд мэргэжлийн зэрэг олгох ажлын үндэс суурийг тавьсан байна. Тэгш хамран сургах боловсролын чиглэлээр сүүлийн жилүүдэд шинэ залуу үеийнхэн хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өнөөдөр нийт сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгч нар өдөр тутмын сургалтын үйл явц, тэдэнтэй ажиллах арга барилыг тэр болгон эзэмшиж чадахгүй байгаа нь нууц биш юм. Мөн эдгээр хүүхэдтэй ажиллахад анхаарах зүйл, сэтгэл зүйн үүднээс судлах мэдлэг дутуу, гарын авлага зөвлөмж хомс байна. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй ба боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүд нь нийгэм хамт олноос тусгаарлагдан тэдний цөөнх нь тусгай сургуульд хамрагдаж дийлэнх нь боловсролд хамрагдах боломжгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын 28-р зүйлд заахдаа бүх хүүхэд адил тэгш эрхтэйгээр боловсрол эзэмших эрхтэй гэж заасан байдаг.

Мөн 29-р зүйлд хүүхэд бүхний авьяас чадварыг дээд зэргээр хөгжүүлэхийг чухалчилсан. Конвенцын 2-р зүйлд хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс болоод ялгаварлан гадуурхах ёсгүй гэж заасан байдгийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгоод зогсохгүй тэдэнд чанартай боловсрол олгох “иргэн” төлөвлүүлэх нь төрийн үүрэг нь мөн гэж заажээ.

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрох эрхийг хангахтай холбоотой хуулиуд, хөтөлбөрүүдийг гарган хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрийн цөм нь 2002 онд батлагдсан боловсролын багц хууль юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байдлын талаар статистик мэдээ хангалтгүй байгаа бөгөөд баримтууд нь хоорондоо зөрүүтэй байна.

Улсын Статистикийн газраас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2004 онд хийсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэг удаагийн бүртгэл түүвэр судалгаанд Монгол улсад нийт 69263 хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүртгэгдсэний 12,7% нь 0-19 насныхан байна.

2004 - 2005 оны байдлаар ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хүүхдийн 9%, сургуулийн гадна байгаа суурь боловсрол эзэмших насны нийт хүүхдийн 11,1%-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзэлж байгаа бөгөөд тэдгээр хүүхдийн 21,6% нь бие эрхтний болон оюун ухааны бэрхшээлээс болоод сургууль завсардсан байна.

ЭМЯ-ны статистик мэдээнд манай улсад нийтдээ 34 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа бөгөөд тэдний зөвхөн 36,8% нь сургуульд сурах боломжтой бөгөөд сургуульд суралцаж буй хүүхдэд тохиолдож буй бэрхшээлээс үзэхэд тэдний 46,1% нь хичээлээ бүрэн ойлгодоггүй, 46,6% нь бусад хүүхэд шоолж дээрэлхдэг гэж хариулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэдэгт хувийн болоод нийгмийн шалтгаанаас үүдэн сурч хөгжих үйл явцад нь хүндрэл учирч байгаа хүүхдийг багтаан авч үздэг.

Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал.

Судалгааны тайлан

2006 он

Судалгаанд хамрагдсан, сургуульд сурдаггүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн хэлбэр.

№	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр		Сургуульд сурдаггүй хүүхдийн эзлэх хувь
1	Хараа	Харааны бэрхшээлтэй	0.9
		Сул хараатай	13.2
2	Сонсгол	Сонсголын бэрхшээлтэй	3.3
		Сул сонсголтой	6.6
3	Хэл	Огт ярьдаггүй	8.1
		Өөрчлөлттэй	2.6
4	Сэтгэц	Хүнд архаг	1.1
		Өөрчлөлттэй	1.1
5	Оюуны бэрхшээлтэй	Хүнд	4.7
		Хөнгөн	5.5
6	Тархины гэмтэл	Хүнд	13.9
		Хөнгөн	6.1
7	Хөдөлгөөний	Гар	3.5
		Хөл	15.8
		Нуруу нугас	1.7

8	Дотор эрхтний	4.9
9	Сурах бэрхшээлтэй	2.1
10	Уналт таталттай	2.7
11	Бусад	2.7

Дээрх судалгаа тоо баримтуудаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамт олных нь дунд нийгэмшүүлэх сургах, тэдгээртэй ажиллах арга замыг боловсруулах нь өнөөдөр нэн чухал асуудлын нэг болж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэхэд:

- Сэтгэл судлалын судалгаа ба оношилгооны энгийн аргуудыг боловсруулах
- Хvvхэд яагаад сурах бэрхшээлтэй болдог тухай судалгаа хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах боломжийг судлах
- Бэрхшээлээс гарах арга замыг судлах асуудлууд нэн тэргүүний зорилт болоод байна.

Орчин үеийн дэлхийн боловсролын чиг хандлагад шинэ үеийн залуу халааг мэдлэг боловсролын зөв зүг рүү хандуулж тэд өөрсдийн ажил амьдралынхаа үйл явцад хурдацтай олон өөрчлөлт, шинэчлэлтэй тулгарах учраас энэ бүхэнд уян хатан дасан зохицож, цаг алдалгүй бэрхшээлтэй тусган авч байх чадварыг эзэмшүүлэхийг чухалчилсан байдаг. Энэ үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан тэдний онцлог хэрэгцээнд тулгуурласан боловсролын үйлчилгээнд аль болох бага наснаас нь хамруулах нь чухал билээ. Хүүхэд хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаанд татан оролцуулахад чиглэсэн хүүхэд төвтэй орчин байгуулах зорилт бол хэрэг дээрээ сургууль цэцэрлэгийн шинэчлэл хийх тухай асуудал юм. Тиймээс сургууль цэцэрлэгийн хамт олон, удирдах ажилтан багш эцэг эхээс тал бүрийн дэмжлэг туслалцаа шаардагдах нь дамжиггүй юм.

Хэрвээ бид үйл ажиллагаагаа зөв зохистой зохион байгуулж чадвал боловсролын чанарт ахиц гарган нээлттэй, чанартай, суралцагчдын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэн бүх хүүхдэд ялангуяа бэрхшээлтэй хүүхдэд үр өгөөжөө хүртээдэг болгох асуудлыг голлон анхаарсан үр дүнтэй ажиллагаа болох бөгөөд эдгээр хүүхдүүдийг нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Учир нь нийгмээс хүүхдийн хөгжлийн бэрхшээлд хандах, сөрөг хандлага нь тэднийг гадуурхах байдал бий болгож боловсролд хамрагдахад нь саад учруулах нь элбэг байдаг.

Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суралцахад нь тулгарч байгаа саад бэрхшээлийг судлан, саад тогторгүй элэгсэг орчныг хүүхдэд зориулан бий болгож үүнийг хүүхдийн хувийн хэрэгцээ болгон боломжид нийцсэн хэлбэрээр гүйцэтгэхийн ач холбогдлыг нээн гаргаж өгдөг.

Сурах бэрхшээлтэй хүүхдүүдийг судалж, тэдгээртэй ажиллах арга замыг тодорхойлсноор эдгээр хүүхдүүдэд боловсролыг хүртээмжтэй олгох, тэгш хамруулах, тэднийг хамт олны дунд сурган хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, ирээдүйн амьдралд бэлтгэх арга замыг тавих боломж нээгдэнэ.

Судалгаа туршилтуудыг бодтой шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамт олных нь дунд тэгш хамран сургах, багш, эцэг, эх асран хүмүүжүүлэгч, сургууль хамт олон сэтгэл гарган хамтран ажиллах хамгаас чухал болоод байгаагийн зэрэгцээ:

- Сурах бэрхшээлтэй хүүхэд бусдын тусламжийг авч хөгжих боломжтой. Үүнд олон нийтийн оролцоо чухал үүрэгтэй бөгөөд багшийн зүгээс сурах бэрхшээлийн ангиллыг зөв тогтоож, онцлог шинжийг нь илрүүлж нэг бүрчлэн ажиллаж чадвал тэдний хөгжлийн дутууг гүйцээж, сурах арга барил эзэмшүүлж чадна.
- Хүүхдийн сурах бэрхшээлийг зөв ойлгож, тэдний хувийн бодит боломж, сурах чадамжийг харгалзан, оновчтой, цэгцтэй, зөв зохион байгуулагдсан сургалтыг цаг алдалгүй зохион байгуулж чадвал үр дүнд хүрэх болно.

- Хүүхэд өөртөө итгэж, хүүхэд өөрийнхөө төлөө зүтгэл гаргаж ажилласнаар сурах бэрхшээлээс гарч бусдын адил тэгш хөгжих боломжтой болдог нь олон улсын туршлагаар улам бүр батлагдаж байна. Үүнийг сайн санаат хүмүүсийн дэмжлэг туслалцаа улам бүр баталгаажуулж өгдөг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхэд багшийн туслалцаа, өгөөмөр сэтгэл дутагдаж байдаг. Үүний зэрэгцээ хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг зөв ойлгож, оновчтой илрүүлж, засах арга барилыг тэдэнд зөв ойлгуулж чадсанаар олон нийтийн оролцоонд хүрч чадна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах өргөн боломжийг нээн өгснөөр эдгээр хүүхдүүдийн нийгэмших, хамт олны дунд төлөвших, сурах асуудлыг шийдвэрлэх арга замуудыг шинжлэх ухааны үндэстэй явуулах бүрэн боломжийг нээн өгч, манай улсын тогтолцооны өөрчлөлтөд нийцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг хангахуйц боловсролын үйлчилгээг хөгжүүлэх үйлсэд чухал хувь нэмэр болно.

Дүгнэлт

Хүүхдийн сурах нийгэмших үйл явц нь багшаас оновчтой арга тухайн хүүхдийн өвөрмөц онцлогт тохирсон үйл ажиллагаа шаардана. Сургалтын олон талт арга хэлбэр нь бүтээлцэх үйл явц, багшийн идэвхтэй бүтээлч үйл ажиллагаанаас бүтдэг нарийн төвөгт хүнээр хүн хийх ухаан байдаг. “Адил боломж тэгш харилцаа” нь багшаас хөгжлийн бэрхшээлт хүүхэдтэй ажиллах өргөн боломжийг нээж өгнө. Ингэснээр ялган тусгаарлах арга ажиллагаа хүүхдүүдийг бие биеэсээ айх бие биеэ үл хайхрах ялгаварлах сөрөг хандлагаас зайлсхийх боловсролд тэгш хамруулж нийгэмших үйл явцад илүү дөхөмтэй болно.

Ном зүй:

1. Боловсролд тэгш хамруулах. Сургалт семинарын материал УБ., 2004.
2. Тэгш хамруулан сургах бодлого. Хүүхдийг ивээх сан /Англи/ БСШУЯ/ УБ., 2004.
3. Тэнгэрийн элч. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах үлгэрчилсэн зөвлөмж УБ., 2003.
4. Л.Рэнцэнханд. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамт олны дунд нийгэмшүүлэх, тэдгээртэй ажиллах арга зам. Магистрын зэрэг горилсон ажил УБ., 2005.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өмнөх боловсролд тэгш хамран сургах сургалтын асуудал. Сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын цуврал гарын авлага УБ., 2004.
6. Хүүхэд бүхэн жаргалтай байг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо Канад сан. УБ., 2000.
7. Монгол дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал УБ., 2006.
8. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг хөгжүүлэх нь УБ., 2004.